

Х-1, Д-1, ХН-113, Нугалбар-2

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ГЭР БҮЛИЙН ЭРХ ҮҮРГИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР АНГИ: Аливаа төрсөн, үрчилсэн, үхсэн ба эр эм бололцсон салсан хүмүүсийг дансанд тэмдэглэх нь

50. Тус усын дотор аливаа төрсөн үрчилсэн үхсэн ба эр эм бололцсон салалцсаныг тоо зэргийг нарийн ногдоор тодорхойлуулж хойч өдөр байцаах тэмдэг болговоос зохих тул орон нутгаа захиргааны газруудаас эрх эмийн дансанд оруулан тэмдэглэвээс зохихоос гадна дотоод явдлын яамнаас ерөнхийлөн хянаваас зохимуй. Тайлбарлах нь эр эм бололцох зэргийг тусгай тэмдэглэх явдлыг эдүгээ үүсгэн гүйцэтгэхийн уг бодлого болвоос хүнийг завсар даган харилцах эрх үүргийг тодорхойлуулж эр эм холбох явдлыг хувьсгалын байдалд нийлэлцүүлэхээс гадна хөрөнгө хогшил ба эр эм үр хүүхдийн эрх ашгийг тус тус хамгаалах хэргийг дөхмөөр явуулах бодлого болой.

51. Дээрх зүйлд заасан дансуудыг зохих этгээдээс бичиг буюу амаар мэдүүлсэнг баримталж түүний үргэлж буюу түр оршин суугаа газрын ойр бүхий хотын ба аймаг хошуудын захиргааны газраас гүйцэтгэвээс зохимуй. Тайлбарлах нь:

1. Дотоод явдлын яамны тогтоолоор дээрх тавьд заасан эр эм салалцахаас бусад дөрвөн дансыг зарим нэг сумын газар гүйцэтгэвээс зохимуй
2. Гадаад улсад суугаа тус улсын харьяат нарыг энэхүү хуулийн тавь, тавин нэгүүдийн ёсоор дансанд тэмдэглэж мэдүүлэх хэргийг тэрхүү газар суугаа тус улсын элчин буюу төлөөний түшмэд гүйцэтгэвээс зохимуй.
3. Гадаад улстай харилцан хэлэлцэж тогтоож дагаж буй зүйл байх ахул тус улсад оршин суугаа гадаадын хүмүүс завсарт эр эм бололцсон зэргийг энэхүү хуулийн тавь ба тавин нэг дэх зүйлүүдэд заасан явдлыг харьяат газар тэмдэглүүлэн гүйцэтгэж болох боловч энэхүү хуульд заасан эр эм бололцоход баримтлах зүйлүүдийг дагаж гүйцэтгэвээс зохимуй.

52. орон нутгийн захиргааны газруудад эрхлэн гүйцэтгэх дансад нь

1. Төрснийг тэмдэглэх
2. Үрчилснийг тэмдэглэх
3. Үхсэнийг тэмдэглэх
4. Эр эм болоцсоныг тэмдэглэх
5. Эр эм салалцсаныг тэмдэглэх эдгээр зүйлүүд болмуй.

52.1. Дээрх зүйлүүдэд заасан дансыг дотоод явдлын яамнаас эрхлэн тусгай маягийн ёсоор үйлдэж гүйцэтгэмүй.

52.2. Ул дансдад тэмдэглэхүйд хураангуйлах буюу элдвээр засварлаж үл болох боловч хэрэв нэмэх хасах зэргээр завсарлах буюу өөрчлөхүйд хүрвээс тийнхүү үйлтгэсний даруй эрх биш ямар ямар үг үсгийг хэрхэн засварласан өөрчилсөн зэргийг тусгай бөгөөд тодорхойгоор мөнхүү данснаа бичиж мэдүүлсэн ба суулцсан гэрчийн этгээдүүдэд уншиж сонсгоод гарын үсэг зуруулж түүнээ уул данснаа тэмдэглэсэн албаны хүмүүс өөр мөн үсэг зурж баталваас зохино.

52.3. Аливаа төрсөн өөрчилсний зэрэг хэргийг зохих данснаа тэмдэглэсний даруй уул мэдүүлсэн этгээдэд уншиж сонсгоод гарын үсгийг зуруулах бөгөөд хэрэв тэрхүү этгээд бичиг үсэг мэдэх аваас бусад бичиг үсэг мэдэх этгээдээр үсэг зуруулахаас гадна уул дансанд гүйцэтгэсэн албаны хүмүүс мөн өөрөө гарын үсэг зурмуу.

52.4. Аливаа хүн мэдүүлсэн зүйлүүдийг нэгэн зэргээр гурван хувь үйлдэж нэгийг нь уул газар үлдээн хадгалж нөгөө нь зохих этгээдэд үнэ төлбөргүйгээр олгоос гадна гурав дахийг нь дотоод явдлын яамнаа тогтоосон хугацаанаа хошуу ба аймгийн яамаар уламжлуулан мөн яамны зохих хэлтэсд мэдүүлвээс зохимуй.

52.5. Уул дансанд нэгэнт тэмдэглэн гүйцэтгэсэн зүйлүүдийг зохих этгээдээс үл зөвшөөрөх тэмцэх учир тохиолвоос шүүх таслах газар мэдүүлж хянан тогтоолговоос зохихоос гадна хэрэв тэмдэглэн гүйцэтгэсэн зүйлүүдэд зөвхөн санамсаргүйн харгаагаар үйлдсэн эндүүрэл байх ахул түүнийг зохих захиргааны газар дотоод явдлын яамны зохих хэлтсийн тушаал зааврыг баримтлан засан өөрчилж болмуу.

ХОЁРДУГААР АНГИ

Аливаа төрсөн үрчилсэн үхсэн ба эр эм бололцсон салсан этгээдийг данснаа тэмдэглэх заавар

НЭГ. Төрснийг данснаа тэмдэглэх нь

53. Аливаа төрснийг данснаа тэмдэглэх тухайн хэргийг төрсөн өдрөөс эхлэн 2 сарын дотор мэдүүлэн гүйцэтгэвээс зохимуй.

53.1. Төрснийг зохих газар мэдүүлэн данснаа тэмдэглэхүйд нялхсын эцэг эх хоёулаа буюу эс бөгөөс нэг нт мэдүүлэн гүйцэтгэх бөгөөд хэрэв дээрх өвчин тохиолдсон буюу өгсөн аваас ураг төрлийн буюу хорины дарга жич эх нялхсыг хамгаалах газраас мэдүүлж гүйцэтгүүлвээс зохимуй.

53.2. Дээрх зүйлүүдэд заасан ёсоор мэдүүлэхүйд нялхсын төрсөн газар сар өдөр эр эм алин болох ба өгсөн нэр эцэг эхийн нэр нас овог ажил тэдний суух нутаг уул хүүхэд хэддүгээр болох зэргийг хамт тодорхойлвоос зохимуй.

53.3. Аливаа үр хүүхэд эхийн дотор өгч гарсан буюу төрсний даруй өгсөн аваас эрх биш зохих газар мэдүүлж данснаа тэмдэглүүлвээс зохимуй. Тайлбарлах нь: Үхэж төрсөн хүүхдийг төрсний данснаа тэмдэглэхээс гадна үхэгсдийн данснаа мөн тэмдэглэвээс зохимуй.

53.4. Аливаа эцэг эх нь үл мэдэгдэх нялхсыг эрх биш төрсний данснаа тэмдэглүүлвээс зохино. Түүний олсон этгээд зохих газар мэдүүлэх дахин тэрхүү нялхсыг хаанаас олсон мөн олсон сар өдөр эр эм жич биенд мэнгэ тэмдэг буй үгүй буй аваас ямар болох төрсөөр төсөвлөвөөс хэд хоног болсныг нялхсын хамтаар хуудас бичиг байсан эссэн уул хүүхдийг ямар этгээдэд олгосныг зохих албаны газар мэдүүлж тусгай тогтоолд оруулан гүйцэтгэсэн явдлыг хамтаар мэдүүлэн тодорхойлвоос зохимуй.

ХОЁР. Үрчилснийг тэмдэглэх нь

54. Аливаа нялхсыг буюу насанд хүрээгүй багачуудыг үрчилэхүйд эрх биш тэдний эрх ашгийг урьтал болговоос зохино.

54.1. Энэхүү хуулийн нэгдүгээр бүлгийн 11дүгээр зүйлийн ёсоор бусдыг асран хамгаалах эрхийг хасагдсан хүн бусдын үр хүүхдийг үрчилж үл болмуй.

54.2. Үрчлэгдсэн хүүхдэд уул үрчилсэн этгээдийн овгийг хэрэглүүлж болмуй.

54.3. нялхас ба багачуудыг үрчлэхэд эх буй ахул тэдгээрийн зөвшөөр авч гүйцэтгэвээс зохимуй.

54.4. Аливаа эр эм бололцсон этгээдүүдийн нэг нь хүүхэд багачууд үрчлэхийг хүсвээс нөгөө эр эмийн зөвшөөрлийг гүйцэтгэвээс зохино.

54.5. Арван насанд хүрсэн хүүхдийг үрчлэхэд тэдгээрийн зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэж үл болмуй.

54.6. Аливаа үрчлэгдсэн хүүхэд үрчилсэн этгээдийн төрсөнтэй нэгэн адил эрх үүргийг эдэлвээс болмуй.

54.7. Аливаа үрчилсэн хүүхдийн эрх ашгийг хамгаалахын тулд хэн ч атугай уул үрчилсэн хэргийг устгах хүсч газар мэдүүлэж мэдүүлж болмуй.

54.8. Аливаа нялхас багачуудыг үрчилсэн хэргийг зохих шүүх таслах газраас шийтгэн олгохдоо уул үрчилсэн этгээдээс эгүүлэн авч төрсөн эцэг буюу зохих газар асран хүмүүжүүлэхээр тушаал өгөхүйд тэрхүү хүүхдийг тэжээх зэргэд зарцуулах зүйлийг мөн үрчилсэн этгээдээс гаргуун гүйцэтгэхээр тогтоож болно.

ГУРАВ: Үхсэнийг тэмдэглэх нь

55. Аливаа үхэгсдийн тухай үхсэн өдрөөс хойш 2 сарын дотор зохих газар мэдүүлмүй.

55.1. Дээрх зүйлийн ёсоор мэдүүлэх явдлыг наснаас нөхцөгсдийн ураг төрлийн зэрэг хүмүүс буюу хэрэв тийм этгээд байхгүй ахул хорины дарга буюу эмнэлгийн ба гяндны газар үхсэн ба мөнхүү албаны газруудаас гүйцэтгэвээс зохимуй.

55.2. Аливаа наснаас нөхцөгсдийг данснаа тэмдэглэхээр мэдүүлэхэд түүнийг нэр овог, нас, өрх ам аль сар өдөр газар ямар шалтгаанаар үхсэн ба мэдүүлсэн хүн өөрийн нэр овог нутаг зэргийг хамтаар тодорхойлвоос зохимуй.

55.3. Дээрх 55 ба 55.1-д заасан мэдэх хэрэг явдлыг үл мэдүүлэх буюу тогтсон хугацааг алгуурлан саатуулваас цаазын бичгийн ёсоор шийтгэмүй.

55.4. Аливаа хүн бусад захиргааны газар наснаас нөхцвөөс тэрхүү орон нутгийн захиргааны газраас үхэгсдийн данснаа тэмдэглэн гүйцэтгэж уул хүн захиргааны газар мэдэгдэн гагцхүү өрх амын данснаас хасуулваас зохимуй.

ДӨРӨВ. Эр эм бололцсоныг тэмдэглэх нь

56. Аливаа эр эм бололцогсдыг харьяат захиргааны газар зохих данснаа тэмдэглэмүй.

56.1. Аливаа эр эм бололцогсдыг зохих данснаа тэмдэглэхийн инару /нааш/ харьяат албаны хүнээс тэдгээрийн нэр овог насны зэрэг зүйлүүдийг энэхүү хуулийн ёсоор асууж лавласны дараагаар гүйцэтгэвээс зохимуй. Тайлбарлах нь, эр эм бололцогсдыг зохих газрын данснаа тэмдэглэхүйд энэхүү хууль дүрэмд заасан үл нийлэлцэх харштай зүйл байхгүй хэмээн гарын үсэг зурсан хуудас мэдүүлвээс зохих буйгийн хэрэв түүнд худал хуурмагаар

мэдүүлсэн зүйл гарваас худал хуурмагаар мэдүүлсэн гэрчийн эдгээдтэй нэг адил шийтгэмүй.

56.2. Аливаа хүн эр эм бололцсоны даруй зохих хууль ёсоор мэдүүлж эс тэмдэглүүлсэн ахул дараа хэрхэн эр эм бололцсоноо тодорхойлон мэдүүлж зохих данснаа тэмдэглүүлэн гүйцэтгэвээс зохимуй.

56.3. Эр эм бололцсоныг зохих данснаа тэмдэглүүлсний даруй харьяат албаны хүнээс уншин сонсгож гарын үсэг зуруулсны даруй эр эм бололцсонд тооцмуй. Тайлбарлах нь, гадаадын харьяат хүн завсар буюу монголын харьяаттай тус улсын хязгаарын дотор эр эм бололцох аваас энэхүү хуулийн ёсоор данснаа тэмдэглүүлвээс зохимуй.

ТАВ. Эр эм салалцагсдыг зохих данснаа тэмдэглэх нь

57. Аливаа эр эм салалцагсдыг зохих данснаа тэмдэглэхээс гадна анхан эр эм бололцсоныг тэмдэглэсэн данснаа тусгай хүснэгт тэмдэглэвээс зохимуй.

57.1. Аливаа эр эм салалцагсад нь шүүх таслах газраас тогтоолоор гүйцэтгэсэн аваас ямар шүүх таслах газар хэзээ хэддүгээр тогтоолоор шийтгэснийг зохих захиргааны газар данснаа тэмдэглүүлвээс зохимуй.

57.2. Аливаа хүн эр эм салалцахыг хүсвээс зохих захиргааны газар шууд мэдүүлэх ахул уул газрын албан тушаалын хүн зохих данснаа тэмдэглэхийн инару /нааш/ чухам салалцсугай хэмээсэн хоёр этгээдээс хамт мэдүүлсэн эссэнийг хянаж гүйцэтгэвээс зохимуй. Тайлбарлах нь, хэрэв эр эм хоёр завсарт тэмцэлдэх зүйл байх аваас зохих шүүх таслах газар шилжүүлмүй.

ГУРАВДУГААР АНГИ. Эр эм бололцоход баримтлах зүйлүүд нь

58. Арван найман насанд хүрсэн хүн эр эм бололцож болмуй.

58.1. Эр эм бололцохыг зохих данснаа тэмдэглэхийг хүсч мэдүүлсэн этгээдүүд хоёулаа буюу нэгэн ч нь бусадтай эр эм бололцсон зүйл байх ахул тухайд данснаа тэмдэглүүлсэн эссэн хэмээн үл ялгаварлан данснаа тэмдэглэж үл болмуй.

58.2. Эцэг эх төрсөн үр хүүхэд ба нэгэн эцэг эхийн ах эгч дүү нар завсардаа эр эм бололцсугай хэмээх аваас данснаа тэмдэглэж үл болмуй.

58.3. Эр эм бололцох явдлыг хоёр этгээдийн санал нийлэлцэх аваас ёсоор гүйцэтгэж болмуй.

58.4. Эр эм бололцох явдалд угсаа ба шашин шүтлэгийг хэлэлцэж үл болмуй

58.5. Эр эм бололцоход лам хуваргууд ба чавганц болж эр эм бололцохыг цээрлэсэн хүмүүс хэмээн ялгаварлаж саатал боодол хийж үл болмуй

ДӨРӨВДҮГЭЭР АНГИ: Эр эм салалцах тухай

59. Эр эмийн нэгэн нь наснаас нөхцөхийн хамт уул барилдлага нь тасармуй.

59.1. Эр эмийн барилдлага нь амьд бүхий цагт салалцваас тасарч болмуй

59.2. Эр эм бололцсон хоёр этгээдийн хамтын дур санал буюу аль нэгэн ч дур саналаар салалцаж болмуй.

59.3. Эр эм салалцахыг хүсч мэдүүлэхүйд анх эр эм бололцсон үнэмлэх хуудас буюу эр эм бололцсоноо батлах өөр өөрийн гарын үсэг зурсан хуудас гаргаж данснаа тэмдэглүүлсэн явдлыг тодорхойлуулваас зохимуй.

59.4. Эр эм салалцахыг хүсэгчид завсарт заан үл нийлэлцэх ахул зохих шүүх таслах газар мэдүүлж шийтгүүлвээс зохимуй.

59.5. Хэрэв салалцах эр эмийн дур санал нийлэлцэх аваас харьяат орон нутгийн захиргааны газар мэдүүлж болмуй.

59.6. Данс эрхлэх албан тушаалын яамнаас салалцахаар мэдүүлсэн этгээдийн завсрын дур саналыг нийлэлцснийг урьдаар лавлуулаад хэрэв үнэхээрийн нийлэлцсэн ахул даруй зохих данснаа тэмдэглэхээс гадна мөнхүү этгээдүүдэд энэхүү хуулийн 52.1-д /гаргацгүй/ заасан үнэмлэхийг олгомуй.

59.7. Аливаа эр эм салалцах хэргийг шийтгэн тасалсны дараа хэрэв салалцсан этгээдүүд хүсэх аваас шүүх таслах газрын түшмэлээс тусгай үнэмлэх олгохоос гадна уул тогтоолын хуулбарыг эр эм салалцах дансыг эрхлэх харьяат үндсэн захиргааны газар буюу эс бөгөөс тэгээрийн анх эр эм бололцсоныг тэмдэглэсэн дансыг хадгалж буй газар хүргүүлэн мэдүүлвээс зохимуй

ТАВДУГААР АНГИ: Эр эмийн завсрын эрх үүргийн тухай

60. Эр эм бололцсон этгээдүүд нэгэн адил овгийг хэрэглэж болох боловч хэрэв эр эм хэлэлцэж зохих данснаа тэмдэглэхүйд тийнхүү нэгэн овог хэрэглэхээр эс мэдүүлсэн аваас тус тусын хуучин овгийг хэрэглэмүй.

60.1. Монгол Ард Улсын харьяат аливаа хүн бусад гадаад улсын харьяаттай эр эм бололцсон явдлыг зохих газар данснаа тэмдэглэхүйд тус тусын харьяат улсаас ангижрахгүй хэрэв үлдвээс зохих бөгөөд хэрэв харьяатаас гарахыг хүсэх аваас тухайн хууль дүрмийг баримтлан гүйцэтгэвээс зохимуй.

61. Эр эм бололцсон хүмүүс аливаа аж үйлдвэрийн хэргийг өөр өөрийн дур зоригоор явуулахаас гадна нийтийн өрх хөрөнгийн хэргийг завсарт харилцан хэлэлцэж явуулмуй. Хэрэв эр эм хоёрын нэг нь бус газар шилжин одохыг хэрэг тохиолдвоос нөгөө нь эрх биш түүнтэй дагалдан одох хэмээх явдалгүй болмуй.

61.1. Эр эм бололцсон этгээдийн урьдын хувийн хөрөнгө хогшил нь тус тус байхаас гадна эр эм бололцсоны хойно хураасан зүйлүүдийг хамтын хөрөнгө хогшилд тооцмуй. Хэрэв хамтын хөрөнгө хогшлын завсар хуваахад үл тохирон тэмцэх зүйл гарваас шүүх таслах газраас тогтоовоос зохино. Тайлбарлах нь:

1. Энэхүү зүйлийг эр эм бололцож зохих захиргааны газар мэдүүлэн эс тэмдэглүүлсэн авч хэрэв эр эм бололцсон явдлыг харилцан хүлээх буюу шүүх таслах газраас уг хүмүүсийн эр эм бололцсон явдлыг үнэнд үзэж шийтгэн тогтоосон хэрэгт баримтлан хэрэглэж болмуй.
2. Зохих газар мэдүүлж тэмдэглүүлсэнгүйгээр эр эм бололцсон явдлыг батлах баримт зүйлүүд нь эр эмийн ёсоор хамт аж төрж өрх хөрөнгийн хэргийг мөн хамтаар явуулсанг бусдаас гэрчлэх бие биесээ элдвээр харилцан туслалцаж төрүүлсэн үр хүүхдийг хамт тэжээх хүмүүжүүлэх зэргийн байдалнууд болмуй.

61.2. Эр эм хоёр аливаа хогшлын тухай завсарт хууль ёсоор гэрээ хэлэлцээ байгуулж болмуй. Тайлбарлах нь:

Энэхүү дээрх зүйлийн ёсоор байгуулсан гэрээ хэлэлцээний дотор хоёр этгээдийн хэн ч атугай хөрөнгө хогшлыг эзэрхэн эдлэх тухай эрхийг үндсээр хасагдуулан муудуулах зэрэг зүйл байх ахул түүнийг байгуулсан эр эм хоёр буюу бусад этгээдээс тэдгээрийн эрх ашиг хамгаалахын тулд уг байгуулсан гэрээг устгуулахыг хүсч зохих шүүх таслах газар мэдүүлж болмуй.

62. Эр эм салалцсан этгээдүүдээс нэгэн нь ажил үйлдвэр хийж үл чадах буюу үйлдвэр олдохгүй цаг тохиолдсон болхул салалцсан өдрөөс эхлэн нэг жилийн хугацааны дотор нөгөө хөрөнгө чинээтэй этгээдээс амьдлагын зүйлийг авч байваас зохимуй.

62.1. Дээрх зүйлд дурдсан амьдарлагын зүйлийг эр эм салалцсан эссэн хэмээн ялгаварлах зүйлгүй өгч авалцахаас гадна эр эм бололцсон нь хууль ёсоор зохих захиргааны газар үл тэмдэглүүлсэн боловч энэхүү хуулийн 61.1-дүгээрийн тайлбартай нийлэлцвээс мөн тусламж өгч авалцаж баймуй.

АРАВДУГААР АНГИ: Үр хүүхэд эцэг эх ба ойр ураг төрлийн хүмүүсийн завсрын эрх үүргийн тухай

63. Эр эм бололцож тэмдэглээгүй цагт завсраас төрсөн үр хүүхэд эр эм бололцсон хүмүүсийн үр хүүхэдтэй нэгэн адил эрх эдэлмүй

64. Эх ба нялхсын эрх ашгийг хамгаалахын тул бусадтай жинхэнэ эр эмийн барилдлагатай үгүйг ялгаварлан жирэмсэн эхнэр хүүхдийг төрүүлэхийн инару буюу төрсний хойно ч зохих захиргааны газар түрүү үрийн жинхэнэ эцгийн нэр овог ба оршин суугаа газрыг мэдүүлэн илтгэвээс зохимуй. Тайлбарлах нь,

1. Ийнхүү мэдүүлсэн зүйлийг харьяат захиргааны газраас уул нэр заасан эцэг болох хүнд сонсгоод хэрэв түүнээс нэгсарын дотор үл хүлээх мэдүүлэг эс гарваас төрсөн эцэгт тооцож зохих данснаа тэмдэглэн гүйцэтгэмүй.
2. Аливаа эхнэр хүүхэд төрүүлсэн хойно түүнийг эцгийн зааж илтгэсүгэй хэмээх ахул мөн шүүх таслах газар мэдүүлэх бөгөөд хэрвээ түүнийг уул газраас зүйтэйгээр үзвээс тусгай тогтоол үйлдэж тэдний нэр заасан эцэг болох хүнээс хүүхдийг төрүүлэх ба тэтгэх сурган боловсруулах тухай зардал шийтгэлийг гаргуулахаас гадна эеийн жирэмсэн явсан цагийн ба хүүхэд төрүүлсэн хойно зургаан сарын хугацааны амьдарлагын зэргэд зарцуулсан ба зарцуулах зүйлд эцгээс гаргалцуулваас зохимуй.

65. Эцэг эх болвоос өөрийн үр хүүхэд зохих эрхийг зөвхөн тэдгээрийн тус ашгийг хамгаалахын тулд эдлүүлэх бөгөөд хэрэв уул эрхийг зүй бусаар хэрэглэхүйд хүрвээс зохих шүүх таслах газраас шийтгэн хасч болмуй.

66. Эцэг эх болох хүмүүс нэг овогтой аваас мөн түүний овгийг хэрэглэмүй. Хэрэв тус тус овогтой аваас хүүхдийн овгийг завсардаа хэлэлцэж тогтоомуй. Хүүхдийн эцэг чухам хэн болох нь үл мэдэгдэх ахул эхийн овгийн хэрэглүүлмүй. Эр эм салалцах хүүхдээ анх хэрэглүүлсэн овгийг хэвээр хэрэглэмүй.

67. Эр эм хоёрын нэг нь Монгол Ард улсын харьяат нөгөө нь бусад улсын харьяат болгох агаад үр хүүхэд төрүүлэхүйд тэдний нэг нь Монголын дотор байсан ахул хүүхдийг уул хүүхдийг Монгол улсын харьяатад тооцмуй. Хэрэв эцэг эх хоёрын нэгэн нь Монголын

харьяат бөгөөд эр эм хоёулаа бусад улсад оршин суух үед үр хүүхэд төрүүлвээс түүнийг аль улсын болох явдлыг завсар хэлэлцэж тогтоовоос зохимуй.

68. Эцэг эх хоёр үр хүүхдийг ямар шашин шүтлэгийг дагах тухай завсарт хэлэлцэн тогтоосон зүйл байх авч түүнийг олиг зүйд нийлэлцсэн хэмээж үл болмуй.

69. Үр хүүхдэд холбогдох аливаа хэрэг явдлыг эцэг эх хоёулаа хамт эрхлэн гүйцэтгэвээс зохино.

70. Эр эм тус тус амьдран суух аваас насанд хүрээгүй үр хүүхэд нь хэнийг дагахыг хэлэлцэж тогтоовоос зохимуй. Тайлбарлах нь, тийнхүү хэлэлцэн тогтоож чадахгүй аваас шүүх таслах газраас шийтгэн тогтоолговоос зохимуй.

71. Эцэг эх нь насанд хүрээгүй үр хүүхдээ сурган боловсруулж алсдаа ард олонд тустай хүнийг бэлтгэх үүргийг хүлээмүй.

72. Эцэг эх болвоос өөрийн насанд хүрээгүй буюу ажил үйлдвэр хийж чадахгүй үр хүүхэд амьдарлагын зүйлийг олговоос зохимуй.

73. Эцэг эх болвоос өөрийн насанд хүрээгүй хүүхдийн эрх ашгийг хамгаалах этгээд мөн болох тул шүүх таслах газар буюу бусад ч газар учрыг төлөөлвөөс зохимуй.

74. Аливаа эцэг эх болох хүмүүс үр хүүхэд нь хууль дүрэм буюу шүүх таслах газрын заавар тогтоолгүйгээр бусад этгээдийн эрх мэдэлд байх ахул эгүүлэн өөр дахин авахыг зохих шүүх таслах газар мэдүүлж болох боловч уул газраас эцэг эхийн эрх хэмээн шууд үл баримтлан гагцхүү тэрхүү багачуудын эрх ашгийг хамгаалах явдлыг чухалчлан шийтгэмүй.

75. Үр хүүхэд болвоос аливаа ажил амьдарлага хийж үл чадах эцэг эх дахин хоол ундны зэргэд зарцуулахыг олгуулж байваас зохимуй.

76. Аливаа насанд хүрээгүй дүү нар ажил үйлдвэр хийж үл чадах учир эцэг эх нь байхгүй буюу хоосон ядуу болох ахул хөрөнгө хогшил бүхий дорогш ах нар эгч нараас зохих тусламж авч амьдарлагад хэрэглэвээс болмуй.

77. Хоосон ядуу бөгөөд ажил үйлдвэр хийж чадахгүй өвөг эцэг эмэг эх завсарт бие биеэ туслалцаж үл чадах аваас зохих тусламжийг өөрийн хүүхэд охидоос авах аргагүй аваас хөрөнгө бүхий ач нараас туслуулваас зохихоос гадна мөн тэрчлэн ач нар нв насанд хүрээгүй зэрэг учир шалтгаан байх ахул өвөг эцэг эмэг эхээс амьдарлагын зүйлийг авч болмуй.